

СОЁМБОМЭДЭЭ

Засгийн ээлжит хуралдаан

ИРГЭДИЙГ ЖИЛД НЭГ УДАА ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГТ ХАМРУУЛНА

2021 оны 6 дугаар сарын 08-ны өдөр болсон хуралдаанаар иргэдийг жилд нэг удаа эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгт хамруулахаар төлөвлөж байна.

18-аас дээш насны иргэдийг жил бүр эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгт хамруулахаар төлөвлөж байна. Үндэсний хөтөлбөр боловсруулах, эрүүл мэндийн үзлэгийн мэдээллийн цахим сан бий болгох, тухайн мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрдөг байх зэрэг чиглэлээр ажиллахыг Ерөнхий сайд үүрэг болгов.

Эхний жилүүдэд өвчлөлийн тохиолдол нэмэгдэж, эрүүл мэндийн байгууллагын ачаалал ихэснэ. Гэхдээ иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл, идэвхтэй амьдралын дадал, хэвшилтэй болгосноор эрүүл хүнд амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна гэж тооцоолжээ.

Хоол боловсруулах, амьсгалын, зүрх-судасны тогтолцооны өвчин өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болдог бол зүрх-судас, хавдар, гэмтэл, хордлого болон гаднын шалтгаантай бусад эмгэгээр түлхүү нас барж байна. Хөдөлмөрийн насны хүн амын өвчлөл, нас баралтын 77 хувийг халдварт бус өвчин, нас барсан гурван тохиолдол бүрийн нэг нь зүрх-судасны өвчинтэй холбоотой байна.

2010 оны байдлаар хорт хавдрын 4,466 шинэ тохиолдол, 3,264 нас баралт бүртгэгдэж байсан бол 2020 онд шинэ тохиолдол 6,702, нас баралт 4,260 болж нэмэгджээ. Шинэ тохиолдлын 73 хувь нь хожуу үедээ буюу II, III шатандаа онош тодорсон, хорт хавдраар өвчилсөн хүмүүсийн 65 хувь нь онош батлагдсанаас хойш жил хүрэхгүй хугацааны дотор нас бардаг гэсэн статистик мэдээ гарчээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой цогц арга хэмжээ авна
Монгол Улсын Ерөнхий сайд

Л.Оюун-Эрдэнэ өнгөрсөн долоо хоногт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй уулзсан. Тулгамдаж байгаа асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхээр холбогдох сайд нарт үүрэг, чиглэл өглөө.

Тухайлбал:

байгууламж, гудамж, талбай зэргийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй хэлбэрээр тоноглох, тохижуулах

- Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангаас дэмжлэг үзүүлэх зэргийг хэлж болно.

25, түүнээс дээш ажилтантай



- 2022 оноос шинэ хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах
- Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийг үе шаттай бэлтгэх

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зарцуулах

- Төрийн бус байгууллагатай хамтран ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, мэргэшүүлэх, суралцах орчин бүрдүүлэх, суралцагчдын тоог нэмэх

- Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлтийг сайжруулах
- Боловсролын цогц үйлчилгээ нэвтрүүлэх

- Орон сууцжуулах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх
- Нийтийн тээвэр, барилга

аж ахуйн нэгж, байгууллага ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах ёстой. Ажиллуулаагүй бол тодорхой хэмжээний төлбөр төлдөг. Төрийн байгууллагууд төлбөр төлөх бус, ажилд авч байхад түлхүү анхаарахыг Ерөнхий сайд чиглэл болгож, аж ахуйн нэгжүүдийг уриаллаа.

Ерөнхий сайд нийгмийн хамгаалал, хөгжлийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөхөөр “Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв”-ийн тэргүүн Ч.Ундрахбаярыг ажиллуулж, сарын дотор орон тооны зөвлөхийн албан тушаалд томилох болжээ.

Монгол Улсад 108 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг бөгөөд энэ нь хүн амын 3.2

хувь гэсэн үг юм. Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 13,629 иргэн хөдөлмөр эрхэлдэг байна. Ирэх оноос Улаанбаатар хот, Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүд ажиллаж эхлэх юм.

Эдийн засгийн идэвх нэмэгдэж байна

Засгийн газар долоо хоног бүр “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл сонсдог.

Сангийн яамны танилцуулгаас үзвэл Ажлын байрыг дэмжих зээл олголт төлөвлөсөн хэмжээний 59.9, репо санхүүжилттэй зээл 23.6, ипотекийн зээл 34.7 хувьд хүрчээ. Хөдөө аж ахуйг дэмжих 205 тэрбум төгрөгийн зээлийг 13,764 зээлдэгч аваад байна. Энэ нь төлөвлөсөн хэмжээний 41 хувь гэсэн үг юм. Зээлийн идэвх нэмэгдэж байгааг Сангийн сайд Б.Жавхлан хэллээ. Цогц төлөвлөгөөний хүрээнд малчид зээл авах хүсэлтээ илэрхийлж байна. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Ажлын байрыг нэмэгдүүлэх гурван хувийн хүүтэй, хоёр их наяд төгрөгийн зээлийн хэмжээг нэг их наяд төгрөгөөр нэмэх, малчдад зээл олгохтой холбоотой асуудлыг судалж танилцуулахыг холбогдох сайд нарт өглөө.

Ерөнхий сайд нийслэл хотод ажилласантай холбогдуулан:

- Түгжрэлийг бууруулах зорилгоор нүхэн гарцууд барихад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх

- Сэлбэ голын дагуух тохижилт, урсцыг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, Бэлх, Сэлхийн үерийн хамгаалалтын далан байгуулах хөрөнгийг 2022 оны улсын төсөвт тусгах

-БГД-ийн 16 дугаар хороо, Гандан орчмыг соёлын аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх санал боловсруулан танилцуулахыг холбогдох сайд нарт үүрэг, чиглэл болголоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	🌧️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 19

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.438.00	3.498.00
CNY 🇨🇳	444.00	447.40
RUB 🇷🇺	38.50	40.20
JPY 🇯🇵	25.73	26.22
KRW 🇰🇷	2.48	2.61

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 28
2021.06.10.
/ПҮРЭВ ГАРАГ/

ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН
МОГОЙ САРЫН ЕСӨН УЛААН
ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Эрлэг лугаа учирна

Наран ургах, шингэх:
04.53-20.50

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Суудал:

Шороо

Аргын тооллын 6 сарын 10. Пүрэв (Бархасвад) гараг. Билгийн тооллын 30, шарагчин үхэр, гөрөөсөн толгой-4 од, суудал шороо, мэнээ 9 улаан, хотол чуулганы барилдлагатай өдөр. Өдрийн нар ургах/шингэх цаг: 04:53-20:50. Өдрийн сайн цаг: Могой(09:40-11:40), бич(15:40-17:40), гахай(21:40-23:40), бар(03:40-05:40), туулай(05:40-07:40) болой. Үс бүү засуул эрлэг лугаа учрах тул муу цээрлэвэл зохилтой. Хол газар явагсад баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Могой, тахиа, бар, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Харин хонь, луу, нохой, үхэр жилтнээ сөрөг муу. Санасан хэрэг бүтнэ. Өндөр суудалд сууж эхлэх, туг дарцаг хийсгэх, урлан бүтээх, дархлах, эрдэм ухаанд суралцах, цэрэг хөдөлгөөх, шинэ малгай, хувцас өмсөх, бэрийн үйл, үхэсдийн үйлд муу.

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИНД БАЯРЛАЛАА



Исламын Найрамдах Афганистан улсад явагдаж байгаа “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагааны хүчний командлагч, генерал Скот Миллер Монгол Улсын төр засаг болон Зэвсэгт хүчний удирдлагад талархал илэрхийлсэн захидал ирүүлээ. Захидалд “Эрхэм анд хошууч генерал Д.Ганзориг танд энэ өдрийн мэнд хүргэе. Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол

Улсын Зэвсэгт хүчний нийт цэргийн багуудад “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагааны хүчний командлагчийн зүгээс баяр хүргэж, талархал дэвшүүлье.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багууд нь “Шинэ кабул бааз”-д байрлах олон улсын эвслийн цэрэг, “Афганистаны Үндэсний аюулгүй байдлыг хангах хүчин” болон энгийн ажилчдыг хамгаалах түүнчлэн баазын аюулгүй байдлыг хангах үүргээ нэр төртэйгөөр амжилттай гүйцэтгэсэн шилдэг энхийг сахиулагчид юм. Монгол Улсын эр зориг, тэсвэр хатуужил, үүрэг гүйцэтгэлт өндөр энхийг сахиулагч дайчдын Кабул хотын аюулгүй байдлыг хангахад оруулсан хувь нэмэр хэмжээлшгүй. Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь өмнөө тавигдсан үүргээ мэргэжлийн ур чадвар,

сахилга зохион байгуулалтын өндөр түвшинд гүйцэтгэсээр ирсэн нь Монгол Улс, Зэвсэгт хүчнийхээ өмнө өргөсөн тангарагтаа хэзээд үнэнч гэдгээ батлан харуулсан явдал юм. “Шийдвэр дэмжлэг” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн дэд хурандаа М.Түвшинжаргал захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн нийт бие бүрэлдэхүүнд үүргээ амжилттай гүйцэтгэсэнд дахин талархал илэрхийлэхийн ялдамд Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб тус бүрэлдэхүүнийг шагнаж урамшуулахыг үүгээр уламжилъя. Монгол Улсын шилдэг энхийг сахиулагчдадаа баярлалаа. Таныг хүндэтгэсэн “Шийдвэртэй дэмжлэг ажиллагааны хүчний командлагч, генерал Скот Миллер” гэжээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

68.287

ЭДГЭРСЭН

55.157

НАС БАРСАН

324/6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2786 (39)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

295

ЭДГЭРСЭН

2450

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 175,156,335

Эдгэрсэн

Нийт: 158,661,003

Нас барсан

Нийт: 3,776,236



Хүүхдийг
КОРОНАВИРУСТ
ХАЛДВАР (КОВИД-19)-
ААС СЭРГИЙЛБЭ!

ЦАХИМ ШУУДАНД

ХИЛИЙН ЧАНАДААС

БЭЛТГЭЛ ОФИЦЕРЫН СУРГАЛТ БОЛОВ



Өмнөговь аймгийн ЗДТГ-ы Цэргийн штаб

2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Дайчилгааны бэлтгэл нөөц чухал мэргэжил бүхий офицер бэлтгэх сургалт"-ын 1 дүгээр шатыг эхлүүллээ.

Тус сургалт 6, 7 дугаар саруудад цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа юм. Сургалтад Өмнөговь аймгийн 11 бэлтгэл үүрэгтэн хамрагдах бөгөөд 2021 оны 6 дугаар

сарын 04-ны өдөр Цэргийн штабын дарга хурандаа Ж.Амаржаргал сургалтыг нээж, суралцагсад тодорхой үүрэг чиглэл өглөө.

Сургалт цахимаар зохион байгуулагдаж байгаа учир хөдөө орон нутгаас хамрагдах бүрэлдэхүүнийг бүрэн хамруулахаар ажиллаж байна.

Дэд хурандаа Д.УЛАМБАЯР

ҮНДЭСНИЙ БИЧГИЙН АВАРГУУД ТОДРОВ



Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

"Үндэсний өв, бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх жил"-ийн аяны хүрээнд тосгоны төрийн албан

хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг сорих, түүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор "Үндэсний бичиг-бидний бахархал" уралдааныг 4 төрлөөр зохион байгуулан явуулав.

Тэмцээнд нийт 7 байгууллагын 9 баг оролцсоноос I байрт 29 оноогоор Хараацай цэцэрлэгийн "Титэм" баг, II байрт 28 оноогоор Хараацай цэцэрлэг "Эв" баг, III байрт 22 оноогоор Захиргааны ажлын алба баг, IV байрт 21 оноогоор Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн "Усчин дайчид" баг шалгарсан амжилт үзүүлээ.

ЦЭРГИЙН ГАЛ ТОГОО ӨНГӨ НЭМЛЭЭ

Зэвсэгт хүчний 336 дугаар анги



Ангийн бие бүрэлдэхүүний ажиллаж амьдрахад таатай орчин бүрдүүлэх үүднээс ангийн өнгө үзэмжид шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Энэ удаад цэргийн гал тогоо өнгө үзэмжээ нэмж хугацаат цэргийн алба хаагчдын хооллох ая тухтай орчныг сайжруулахад анхаарч ажиллаж байна.

Тус ажлыг хийж гүйцэтгэхэд ангийн удирдлага, цэргийн гал тогооны хамт олны хичээл зүтгэл ихээхэн байсныг дурдах хэрэгтэй юм.

Мөн ангийн оёдолчин М.Пүрэвсүрэн маш богино хугацаанд 10 цонхны хос хөшиг оёж, цэргийн гал тогооны өнгө үзэмжийг нэмлээ.

5 ДУГААР САРЫН ТӨРСӨН ӨДРИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛОВ



2021 оны 6 дугаар сарын 08-ны өдөр ангийн 5 дугаар сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийн баярыг тэмдэглэн өнгөрүүлжээ. Уг арга хэмжээнд захирагчийн зөвлөл болон Мотобуудлагын батальоны удирдлага оролцож, тэдний баярыг хамтдаа тэмдэглэжээ. Төрсөн өдрөө тэмдэглэж буй дайчдадаа Артиллерийн дивизионы байлдагч Б.Баянмөнх ая дууны мэндчилгээ дэвшүүлж, нийт бие бүрэлдэхүүн 27 хугацаат цэргийн алба хаагчдадаа зориулан бүх оддын дуулсан "төрсөн өдрийн дуу"-гаар ая дууны мэндчилгээ дэвшүүлж гэнэтийн бэлэг бариллаа. Энэ өдрийн арга хэмжээнд зориулан "Цэргийн гал тогоо" сонголттой хоол буюу жунжтай шөл, бинтэй шөл, пүнтүүзтэй хуурга, хуушуур шпагетти, нарийн махан хуурга зэрэг хоолуудаар үйлчиллээ. Төрсөн өдрөө тэмдэглэж буй хугацаат цэргийн алба хаагчид Мотобуудлагын батальон болон цэргийн гал тогооны бие бүрэлдэхүүнд, соёл хүмүүжлийн зааварлагч нарт баярлаж талархсанаа илэрхийллээ.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДЛАА



Монгол цэрэг 2022 оноос эхлэн дэлхийн халуун цэгүүдэд дайн самууны хөлд цөхөрсөн ард түмний энх тайван, эрх чөлөө, аюулгүй байдлын төлөө олон орны энхийг сахиулагчидтай мөр зэрэгцэн зүтгэж, энхийг сахиулах хариуцлагатай үүргийг нэр төртэй гүйцэтгэж байна.

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй хурандаа Д.Энхбаатар захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн МББ ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгээд 8 сарыг үдэж байна.

Дэлхий нийтээр тархаад буй Ковид-19 цар тахлаас батальоны бие бүрэлдэхүүн урьдчилан сэргийлэх зорилгоор вакцинжуулалтын эхний тунд бүрэн хамрагдлаа. НҮБ-ын хангалтаар

олгогдсон "Astrazenica" вакциныг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авч, 1 дүгээр шатны эмнэлэгт хадгалах горимын дагуу хадгалах ажлуудын шат дараатайгаар зохион байгуулж, улмаар UNMISS хүчний командлал болон цэргийн дээд удирдлагын шийдвэрээр дархлаажуулалтын эхний тундаа бие бүрэлдэхүүн 100 хувь хамрагдаад байна.

Вакцинжуулалтын явцад Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон вакцины ач холбогдлын талаар сургалт, ухуулга сурталчилгааны ажлыг түлхүү явуулж, хүн нэг бүрээр эрүүл мэндийн байдлын судалгааг нарийвчлан гарган, эмнэл зүйн удирдамжийн дагуу бэлтгэл ажлыг сайтар хангасны дагуу цэргийн алба хаагчдын дархлаажуулалтыг амжилттай зохион байгууллаа.

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ 350 КИЛОМЕТР ЗАМЫГ ТУУЛААД БАЙНА



Ховд аймгийн Буянт сумын харьяат, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Ховд хотоос Улаанбаатар хот хүртэл 1500 км зайд гүйхээр 6 дугаар сарын 2-ны өдөр гараанаас гарсан. Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбараас анх удааа холын зайд гүйхээр эр зориг, түүхэн шийдвэр гаргасан тэрээр урд шөнө Говь-Алтай аймгийн Дарив суманд хоногдсон бөгөөд 350 орчим километр замыг туулсан амжилттайгаар 9 дэх өдрийн гүйлтээ эхлээд байна.